

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-8
1. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	4-8

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 10 дугаар сарын 28-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 22 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Батшугар, Б.Баярбаатар, Ж.Баярмаа, Б.Дэлгэрсайхан,
М.Нарантуяа-Нара, Д.Пүрэвдаваа, Н.Учрал;
Эмнэлгийн чөлөөтэй: О.Алтангэрэл;
Тасалсан: Х.Баттулга.

Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэр дэвшигч Н.Мягмар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Л.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Ганбат нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Засгийн газраас санал болгосон Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Нэргүйн Мягмарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 19 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
14 цаг 22 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооныхоо гишүүдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Дашдондогийн Ганбат, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр гэсэн гишүүдийн ирцтэйгээр, ирц 56.0 хувиар бүрдсэн байна. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 1 асуудал байгаа.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Бид нар хэлэлцээд эхэлчихсэн байгаа. Одоо энэ үргэлжлэх юм. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алга байна. Тэгвэл ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэж, санал хураалт явуулахад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төлөөллийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул санал болгох эрх бүхий байгууллагад дахин нэр ирүүлэх албан бичгийг Байнгын хорооноос хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газраас ажлын хэсэгт орох албан тушаалтны нэрийг ирүүлсэн тул одоо санал хураалт явуулна. Гишүүдэд нэр дэвшиж байгаа хүний танилцуулга, юмнуудыг тараагаад өгчихсөн байгаа. Мягмар дарга орж ирж байгаа ажлын хэсэгт. Үүнтэй холбогдуулаад асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Цогтбаатар гишүүнээр тасалъя. Асуулт, үг хоёроо нэгтгэчихье хэдүүлээ. Сайнзориг гишүүнд микрофон өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Өдрийн мэнд хүргэе. Би энэ асуудал дээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг дээр Засгийн газрын түвшинд уг асуудлыг хариуцаж байгаа байгууллагын төлөөлөл орж ирж байгаад зарчмыг дэмжиж байна. Өөрөөр хэлэх юм бол Мягмарыг дэмжиж байна. Протоколд үлдээх гээд байгаа юм нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг дээр Улсын дээд шүүхийн дэргэд ажилладаг судалгааны төвийг төлөөлж хүн орж байгаа нь ерөөсөө зүй тогтлын хувьд буруу шүү. Энийг би ингээд 3 дахиа хэлж байгаа. Тийм учраас энэ юу гэдэг

юм бэ, харахад 1 хүн ч болов магадгүй хүн дээр санал тэнцэхэд тэр хүний саналаар дэнслэх гэж байгаа байхгүй юу. Шүүгч нарын төлөөлөл байж болохуйц хүн. Өөрөөр хэлэх юм бол Улсын дээд шүүхийн дэргэдэх тэр судалгааны академи бол цэвэр улсын дээд шүүгч нарт захирагдаж, тэдгээрийн шийдвэр гаргахад шаардлагатай судалгаануудыг хийдэг байгууллага байгаа.

Тийм учраас энэ дээр ерөөсөө бусад судалгааны байгууллага мундсан биш дээ. Эвтэйхэн оруулж ирээд шүүгч бус гишүүнийг ямар нэгэн шүүгч нартай хамааралтай этгээдээр биш байдлаар уг нь сонгон шалгаруулах ажлын хэсгийг зохион байгуулчих байсан юм. Тэгээд манай энэ асуудал дээр ийм буруу жишиг тогтоож байгаа нь туйлын харамсалтай байна. Тэгээд тэр төлөөллөөс орж ирж байгаа залуу сайн дураараа бараг татгалзаад, дараагийн хүнийг орчхоосой гэж бодож байна. Тэгээд ийм байдлаар явахгүй бол ингээд буруу жишиг. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс нэр ирсэн байна лээ шүү дээ. Тэгээд хэн 1 даргад таалагдаагүй юм шиг байна лээ. Тэгэнгүүт сольчихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм байдлаар энэ ажил явж болохгүй ээ. Туйлын харамсалтай байна. Ялангуяа хууль барьдаг Хууль зүйн байнгын хороо Үндсэн хуулийнхаа 2019 оны Үндсэн хуулийн амин сүнс болсон шүүгч, шүүхийн ерөнхий зөвлөлийг сонгон шалгаруулах асуудал дээр шүүгч бус гишүүн болон шүүгч нар өөрсдөө хуралдаад өгчхөж байгаа. Шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулалттай шүүгч нарын ямар нэг хамааралтай этгээдийг ерөөсөө оруулж болохгүй концепц байхгүй юу даа. Гэтэл бид нар ингээд хүчиндээд яваад байдаг. Туйлын харамсалтай байна. Тэгээд Мягмарыг бол зарчмын хувьд дэмжиж байна. Хууль зүй, дотоод хэргийн яам л байх ёстой төлөөлөл нь энэ дээр.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүнд микрофон өгье.

Д.Ганбат: Яах вэ, ер нь энэ орж ирж байгаа залууг бол дэмжиж байна. Мягмар гэнэ үү. Бас Сайнзориг гишүүний яриад байгаа бас зөв л дөө. Ер нь мордохын л хазгай байна уу, ямар байна вэ. Энэ Хууль зүйн байнгын хорооны хийж байгаа ажил чинь. Тэгээд бусад хүмүүст ярьж байгаа, хэлж байгаа юм чинь бол жишээлбэл манай Ардчилсан намын бүлгээс оруулж ирсэн хүнийг ар гэр нь шүүгч юм байна. Болохгүй юм байна гээд л солиулж байх жишээтэй. Яах вэ, тэр байдаг юм байж. Тэгээд бусдад нь адилхан шаардлага тавь л даа. Тэгээд энэ чинь Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус 5 гишүүнийг шалгаруулах энэ ажлын хэсэг чинь эхнээсээ эхлээд л зөв явахгүй бол дараа нь өчнөөн хэл ам гарна шүү. Тэр шүүх чинь болохгүй байна энэ тэр гээд хэл ам чинь эндээс л эхэлж байгаа шүү дээ.

Тэр ажлын хэсгийн ахлагчаар хэдийд нь ямар тогтоолоор хэнийг тавьчихсан юм бэ. Энэ Хууль зүйн байнгын хороо дээр тэгж ярилцаа биз дээ. Ер нь тэр захирамжаар ажлын хэсгийг Их Хурлын дарга тавьдаг нь зөв ч юм уу, буруу ч юм уу. Энэ мэргэжлийн Байнгын хороо нь мэдээд гаргачхаж болдоггүй юм уу. Та нараас тэгээд ямар санал оруулсан юм. Хэнийг тавьсан юм. Жишээлбэл Их Хурлын даргыг хэн орлосон юм. Одоо энэ сарын 16, 17-ны өдөр гэхэд Үндсэн хуулийг зөрччихсөн гээд зөрчил гаргасан дэд дарга чинь байж л байгаа шүү дээ. 16-ны маргаан үүсгэсэн байгаа. 17-ны өдөр Үндсэн хуулийг зөрчсөн гээд гарчихсан байгаа. Тэгээд Шүүхийн ерөнхий зөвлөл чинь өөрөө шүүгч нарыг шалгаруулдаг, шүүхийн хараат бус байгууллагыг хангадаг. Одоо 24 хүн нэр дэвшчихсэн байна гэж байгаа. Эхнээсээ авхуулаад л ийм юм гаргаад байвал энэ 24 хүнээс чинь хэл ам гарна. Олон нийтээс хэл ам гарна. Анхнаасаа ингээд хууль бус юм явуулсан байвал энэ юм чинь цаашдаа явахгүй ээ. Жоохон хариуцлагатай бай л даа. Хэнийг тавьчихаад яасан юм.

Тэрийг чинь эхлээд тодруулъя. Танилцъя. Ямар үндэслэлээр яаж явсан юм. Энэ юм чинь зөв юм уу.

Үгүй ээ, тэгээд бас хар л даа түрүүчийн Байнгын хорооны хурлаар юу вэ, тэр Улсын Их Хурлын гишүүн шалгагдахгүй гэдэг юмыг дэмжээд явуулсан байх юм. Ийм юм хийж болохгүй шүү дээ та нар. Энэ Хууль зүйн байнгын хороо чинь ийм байвал бусад нь яах юм. Ганц 1 зөв юм хэлээд байгаа энэ Сайнзориг гишүүн л хэлэх юм. Энхбаяр гишүүн хэлэх юм. Цогтбаатар дарга тэгээд энэ юмаа анхаар. Алтанхуяг гишүүн бас хэлэх юм. Бас бус гишүүд хэлэх юм. Тэгээд энэ ажил төрлөө жоохон зас л даа. Хуулийнх нь дагуу явуул л даа. Тэгээд хариултыг нь/минут дуусав/

Д.Цогтбаатар: Ганбаатар дарга аа, энэ дээр ийм юу байгаа шүү. Биш ээ, Ганбат дарга аа. С.Ганбаатарын юу бол би бүр өөрөө хойшлуулаад, та өөрөө мэдэж байгаа шүү дээ. Судлаад, нарийвчлаад оруулж ирье гээд би өөрөө хойшлуулсан. Тэгсэн тэр чинь нөгөө хугацаа нь тулчихсан. Үндсэн хуулийн цэц дээр энэ асуудлыг тэгвэл гомдол гаргана гэдэг асуудал явсан байхгүй юу. Тэгэхлээр Хууль зүйн байнгын хороо бид нар дэмжсэн гээд байгаа чинь Их Хуралд оруулж хэлэлцэхийг нь дэмжиж байгаа байхгүй юу. Тэр нь угаасаа хуулиараа Байнгын хороонд орж ирээд, Их Хурал руу бид нар оруулах хугацаатай. Тэр хугацаанд нь оруулахгүй бол Байнгын хороо өөрөө хуулиа зөрчиж байгаа байхгүй юу. Тийм учраас тэр агуулгаар нь дэмжсэн биш, чуулганд оруулж хэлэлцэхийг нь бид нар дэмжээд л явуулж байгаа юм. Бид нар тэгэхгүй бол 14 хоногийн хугацаа байгаа байх. Тэр хугацаа нь яагаад өөрөө бүр албан бичгээр Үндсэн хуулийн цэцэд хандана. Гомдол гаргана гэдэг асуудал албан бичгээр тавьсан. Тэгээд хэлэлцүүлэх нь Их Хурлын бүрэн эрхийн асуудал байхгүй юу. Би бүр хойшлуулаад, тэгсэн чинь байдал чинь ингэж эргэсэн байхгүй юу. Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргана гээд. Их Хуралд хэлэлцүүлэх л байхгүй юу. Их Хуралд ороод хэлэлцэх асуудлаа, одоо тэгээд Их Хурал дээр л энийгээ шийднэ шүү дээ. Үгүй юм байна лээ. Харин Их Хурлын чуулганаар орж шийдэгдэх асуудал байгаа байхгүй юу. Чуулганаар юм байна лээ шүү дарга аа.

Тэгээд энэ дээр яг жинхэнээсээ хэдүүлээ Хууль зүйн байнгын хороо 1 асуудал харин байгаа юм. Энийг бид нар одоо Цэц рүү нь явуулахгүй бол байна шүү дээ. Яг саяын Үндсэн хуулийн цэцийн маргаан шиг ийм маргаантай. Бид нар гишүүд хоорондоо маргаад байгаа болохоос биш, гишүүдийн хооронд энийг эцэслэж, цэг тавьж өгөх юу байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр дараагийн удаа хэн нэг нь ахиад орж ирээд яг энэ асуудлыг тавих юм байна лээ. Тэгэхээр тэр Цэц рүүгээ очоод, эцэслэн нэг талдаа гарахгүй бол бид нар эндээ зүгээр маргаж суугаад бид нарын хэн нь ч Үндсэн хуулийн асуудлаар эцсийн дүгнэлт гаргаж чадахгүй байхгүй юу. Тэр гишүүний эсрэг саналын эсрэг миний санал адилхан гишүүний л санал яваад байхаас эцсийн шийдвэр чинь гарахгүй байгаад байгаа байхгүй юу.

Ажлын хэсэг дээр ийм шүү. Ганбат дарга аа, ажлын хэсэг дээр бол ингэсэн шүү. Ажлын хэсэг дээр надад ямар нэгэн би хүн амьтан оруулж ирж байгаа ерөөсөө юм байхгүй. Та нар бүгдээрээ Монгол жижигхэн мэдэж байгаа. Надад бол оруулж ирж байгаа хүн байхгүй. Одоо ажлын хэсгийн даргаар би тодорхой хүн санал болгосон. Та өөрөө мэдэж байгаа. Тэгээд энэ хооронд чинь Улсын Их Хурлын дарга өөрөө ажил нь өөрчлөгдөөд, энд чинь Их Хурлын дэд дарга Их Хурлын даргын үүргийг гүйцэтгэж байна шүү дээ. Булгантуяа дарга. 10 сарын 20-нд Булгантуяа дарга өөр хүн дэвшүүлээд, тавьсан байна шүү дээ. Номинчимэг гишүүнийг тавьсан байна шүү дээ. Одоо би жишээлбэл энэ асуудлыг чинь оруулаад, зөв талаас нь л яриад л явж байна шүү дээ. Тэгэхдээ энэ институцийн эрх мэдлийн хуваарилалт

чинь миний хүрэхгүй эрх мэдэл байна шүү дээ. Даваагийн Цогтбаатар гишүүн байхгүй байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Ганбат гишүүнд микрофон өгье. Ганбат гишүүн микрофон өгье.

Д.Ганбат: Ер нь Хууль зүйн байнгын хороо зөв ажилламаар байна. Хуулийнхаа дагуу. Тэгээд сонин байдалд оруулаад байх юм ерөөсөө байхгүй. Энэ чинь нүүрсний хулгайчид, Ногоон автобусны хулгайчид өөр юу юуны хулгайчид билээ. Тэр Хөгжлийн банкны хулгайчид энэ тэр чинь одоо хэрээс хэтрээд байна шүү дээ. Сүүлийн 10 жил Ардын нам засаг барьчихсан. Олонх байчихсан. Тэгээд одоо та нар чинь 2 хуваагдчихсан байгаа. Нүүрсний хулгайчид ба нүүрсний хулгайчид бус гэсэн ийм л юм явж байгаа. Нэг их чухал биш л дээ. Чухал бишгүй юм байхгүй л дээ. Үүний цаана хулгайгаа нуудаг байх гээд байна шүү дээ. Үүний цаана өөрсдийнхөө юмыг тавьдаг, хонгилоо угсардаг байх гээд байна шүү дээ. Энэ шударга бус юмтай чинь л би эвлэрэхгүй гэж яриад байна л даа. Тэгээд дараа нь хэл ам гарна шүү дээ энэ чинь. Тэгээд үнэн, худлаа яриад, ямар хэрэгтэй юм бэ. Хэнд хэрэгтэй юм тэр чинь. Тэглээ, ингэлээ гэж ойлголоо. Дараа нь тэгсэн чинь л хувираад л. Тэгээд энэ асуудлыг энэ хүртэл яриад. Тэрийгээ та зохицуулаа. Гэхдээ соль мэдэв үү. Би болохгүй. Гэхдээ тэр нүүрсний хулгаатай багийнхаа хэсгээс тавьдгаа боль.

Д.Цогтбаатар: Мягмарыг оруулж ирье гээд л энэ чинь 3 буцаж байгаа асуудал байхгүй юу даа. Ингээд санал хураалтдаа бэлдье гишүүд ээ.

Монгол Улсын Засгийн газраас санал болгосон Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 87,5 хувиар санал дэмжигдлээ.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 87,5 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол 2025 оны ... дүгээр сарын ... өдөр дугаар Улаанбаатар хот.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай”

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1.6, 77.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 15 дугаар тогтоолоор байгуулагдсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлөн Улсын Их Хурал хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Номингэрэл, Монгол Улсын засгийн газрыг төлөөлөн Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар нарыг нэмсүгэй.

Ингээд сая тийм санал хураагаад батлагдчихсан. Тогтоолыг уншиж танилцууллаа.

Ингээд байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүд ээ.

14.41 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ